

## АНГЛИ ХЭЛНИЙ ТЭМДЭГ НЭР БҮТЭЭХ ‘-al’ БОЛОН ‘-ic’ ДАГАВРЫН АВИА ЗҮЙН ХУВЬСАЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Б.Ганболд\*, ШУТИС

### Abstract

Morphological processes alter stems to derive new words. They may change the word's meaning (derivational) or grammatical function (inflectional). Every language has its own rules about the structure and formation of its words. Affixation occurs when a morpheme is attached to a root. Some people do not realize what the phonological alternation is during the word processing.

English suffixes, or endings, can change the meanings of words. For example, some verbs and nouns can be changed into adjectives by adding an adjective suffix. This research looks at ‘-al’ and ‘-ic’ adjective-forming suffixes. We chose these suffixes, because these suffixes were commonly used to create nouns in our chosen materials.

Some researchers believe that ‘-atic’ is a separate version of suffix from ‘-ic’. Some believe it is a version of ‘-ic’. We agree with the first concept, because if we attach only ‘-at’ suffix it is nonsense, for example: ‘idiomat’, ‘plegmat’. So we believe that ‘-atic’ should be considered a separate suffix. We attached the adjective-forming suffixes ‘-al’ and ‘-ic’ to the noun, depending on the word's ending and composition and vowel alteration. This suffix can be attached to some words directly.

### Түлхүүр үг

Салаа утга, оруулбар, бүтээвэр, эгшгийн сэлгэц, шүргэх болон хамжих гийгүүлэгч

### Удиртгал

Энэ судалгаагаараа бид англи хэлний хэл зүйн байгууллыг судлах, тэр дундаас англи хэлний тэмдэг нэр залгаврын аргаар бүтэх явцад гардаг зарим авиа зүйн хувьслыг хэлний тодорхой баримтад тулгуурлан тайлбарлах оролдлогыг хийсэн болно.

Англи хэлэнд нэрээс тэмдэг нэр залгаврын аргаар үүсэх нь маш элбэг тохиолддог талаар судлаачид тэмдэглэсэн байдаг. Англи хэлний нэрээс тэмдэг нэр бүтээх дагаварт эрдэмтэд дараах дагавруудыг ихэвчлэн оруулсан байдгийг судалгааны бүтээлүүдээс харж болно. Тухайлбал, Марета эка Ауля (2009) нэрээс тэмдэг нэр бүтээх дагаварт *-al*, *-ic*, *-ish*, *-an*, *-ive*, *-ous*, *-y*, *-ary*, *-ist*, *-ant*, *-ate* зэрэг 11 дагаврыг оруулсан байдаг. Тэрээр цааш нь, эдгээр дагавруудад мөн бүтээврийн хувилбарууд байдаг, гээд *-al* дагаврын бүтээврийн хувилбарууд нь *-ual*, *-ial* / *grad+ual* = *gradual*, *part+ial* = *partial* / бөгөөд “-al” дагавар нь бүтээвэр, авиалбарын өөрчлөлт (morpho-phonological modifications)-д орсноор *-(u)ag*, *-ical* гэсэн хувилбаруудыг үүсгэжээ, гэсэн байна.

Марета эка Ауля, үүнийгээ дараах жишээгээр баталсан байна. Жишээ нь: *tubular* (adj) /хөндий, хоолойтой/, *vehicular* (adj) / тээврийн хэрэгсэлд хамаарах/, *theatrical* (adj) / хиймэл. Тэрээр цааш нь, ихэнх үүсмэл нэр үндсүүд нь *-al*, *-ic*, *-ive*, *-ous*, *-ary*, *-ist* гэсэн

залгавруудаар төгссөн байдаг, гээд дараах ишээг авчээ. Үүнд:

Egoistic à egoistical, Journalist à journalistic (мөн бүтээлд).

Бахаса Ингрис (2010), нэрээс тэмдэг нэр бүтээх дагаварт *-al*, *-ic*, *-ar*, *-ary*, *-en*, *-ful*, *-ish*, *-less*, *-like*, *-ly*, *-ous* зэрэг дагавруудыг оруулсан байдаг.

Хэдийгээр англи хэл нь нугармал бүтэцтэй хэлний бүлэгт багтдаг боловч залгаврын аргаар нэрээс тэмдэг нэр бүтэх нь түгээмэл ажиглагдаж байгаа бөгөөд энэ шинжээрээ монгол хэлтэй төстэй байна. Бид энэхүү судалгаагаар хийхдээ ажиглалтын болон таамаглал дэвшүүлэх аргуудыг хослуулан хэрэглэсэн болно.

### Үндсэн хэсэг

Бид энэ судалгаандаа нэрээс тэмдэг нэр бүтээх дээрх дагавруудаас зөвхөн ‘-al’ болон ‘-ic’ дагаврыг сонгон авч эдгээр дагавруудыг нэр үндсэнд залгахад авиа зүйн ямар өөрчлөлт гарч байгаад ажиглалт хийж, тайлбарлах оролдлого хийлээ. Энэ хоёр дагаврыг сонгох болсон шалтгаан нь, бидний түүвэрлэсэн баримтад хийсэн ажиглалтаар маш олон тэмдэг нэр эдгээр дагавруудаар бүтэж байсан тул бүтээлч дагавар

\*✉ ganbold@stda.edu.mn

хэмээн үзсэнтэй холбоотой билээ. Судалгаагаа хийхдээ, ‘-al’ болон ‘-ic’ дагаврыг залгахад үүсэж буй авианы өөрчлөлтүүдийг дагавар тус бүрээр нь бүлэглэн авч үзэх оролдлого хийсэн болно.

1. ‘-al’ дагаврыг нэрийн үндсэнд залгахад үүсэж буй авианы өөрчлөлт

Энэхүү ‘-al’ дагавар нь жинхэнэ нэрээс тэмдэг нэр үүсгэх бүтээлч дагавар бөгөөд нэр үгээс тэмдэг нэр үүсгэх явцад авианы ямар өөрчлөлт болж байгааг дараах жишээнүүдээс харж болохоор байна.

1. Abdomen (n) /мон. гэдэс хэвлий/ → abdominal (adj) /мон. гэдэстэй/

2. Occasion (n) /мон. тохиолдол/ → occasional (adj) /мон. хааяа, ховор/

Эхний хэлний баримт дээр *Abdomen* гэдэг үгийн ‘e’ эгшиг *abdominal* гэдэг үгэнд ‘i’ болон хувирсан өвөрмөц үзэгдэл явагдсан байна. Үүнийг эгшгийн сэлгэц (vowel alternation) гэдэг бөгөөд зарим эгшгийн сэлгэц тухайн үгийнхээ онцлогоос шалтгаалдаг тул тайлбарлах боломжгүй байдаг. Дараах хэлний баримтууд (3,4,5)-аас балархай ‘e’ эгшиг -al дагаврыг залгахад гээгдэж байгааг анзаарч болохоор байна.

3. Cause (n) /мон. учир шалтгаан/ → causal (adj) /мон. учир шалтгаантай/

4. Grade (n) /мон. шат, алхам/ → gradual (adj) /мон. аажим, алгуур/

5. Jove (n) /мон. Бархасбадь гариг/ → jovial (adj) /мон. хөгжилтэй, наргиантай/

Харин (4,5) -р жишээний хувьд, ‘e’ гээгдэж, оронд нь -al бүтээврийн хувилбар болох -ial, -ual бүтээврүүдээр солигдож байгаа бөгөөд чухам ‘i’ -г сонгох уу, эсвэл ‘u’-г сонгох уу гэдэг нь тухайн үгийн онцлогоос хамаарч байна.

6. Habit (n) /мон. зан заншил, зуршил/ → habitual (adj) /мон. энгийн, жирийн, дадамгай/

7. Part (n) /мон. хэсэг/ → partial (adj) /мон. хагас, хэсэгчилсэн/

Дээрх (6,7)-р жишээн дээр байгаа -ual, -ial бүтээврүүд нь -al бүтээврийн хувилбарууд боловч эдгээр бүтээврүүдийг өмнөх нэр үгэнд нь залгах тогтсон хатуу дүрэм байдаггүй тул тухайн үгийнхээ үндсэнд шууд залгадаг онцлогтой болохын анзаарч болохоор байна.

8. Larva (n) /мон. өт, авгалдай/ → larval (adj) /мон. авгалдайны/

9. Malaria (n) /мон. хумхаа өвчин/ → malarial (adj) /мон. хумхаа өвчний/

Харин, (8,9)-р жишээний үгс нь ‘a’ эгшгээр төгссөн байгаа бөгөөд -al дагаврыг залгаснаар давхар ‘aa’ болж, улмаар ‘larvaal’ гэсэн үг үүсэж, салаа утга (ambiguity) үүсэхээс зайлсхийх зорилгоор нэг ‘a’ -г нь гээж ‘larval’ гэсэн үг

үүсгэжээ.

Англи хэлний нэрээс тэмдэг нэр үүсгэх дагаврын тусламжтайгаар үүсэж байгаа “авгалдайны, хумхаа өвчний” зэрэг дээрх үгсийг монгол хэлэнд нэрийн тодотгол гэж үзэж байхад, англи хэлэнд тэмдэг нэр гэж үзэж байгааг монгол, англи хэлний тэмдэг нэрийн нэг ялгаа гэж үзэж болохоор байна.

10. Tube (n) /мон. хоолой, цорго/ → tubular (adj) /мон. хөндий, хоолойтой/

11. Vehicle (n) /мон. тээврийн хэрэгсэл/ → vehicular (adj) /мон. тээврийн хэрэгсэлд хамаарах/

(10,11)-р жишээн дээрээс ажиглахад, ‘-al’ бүтээврийн хувилбар болох ‘-ar’-ыг үгийн үндсэнд залгахын тулд ‘-ar’-н өмнө ‘-ul’ оруулбар (insertion)-ыг жийрэглэж авиа зүйн өвөрмөц үзэгдэл явагдаж байна. Хэрвээ ‘tube’ дээр шууд ‘-ar’ бүтээврийг залгавал ‘tubear’ юм уу эсвэл ‘tubar’ гэсэн тодорхой утгагүй үгс үүсэх юм. Энэхүү ‘tubular’ гэдэг үг үүсэхэд авиа зүйн хэд, хэдэн процесс явагдаж байгаа бөгөөд эхлээд ‘tube’ гэдэг үгийн балархай ‘e’ гээгдэж, үүний дараа ‘-ul’ бүтээврийг жийрэглэн, эцэст нь ‘-ar’ дагаврыг залгаснаар шинэ үг маань үүсэж байна. ‘-ul’ оруулбар орж ирснээрээ энд мөн үгийн өргөлт өөрчлөгдөж байна. Тухайлбал, (11)-р жишээний ‘vehicle’ гэсэн үгийн өргөлтөт үе нь тухайн үгийн хоёр дахь үеийн “-i” дээр байсан бол, ‘-ar’ дагаврыг залгаснаар үгийн өргөлт өөрчлөгдөж “vehicular” гэсэн үгийн гурав дахь үеийн “-u” руу шилжсэн байна.

Монгол хэлэнд, иймэрхүү/ оруулбар гэж байдаггүй залгамал хэл бөгөөд, энэ талаар эрдэмтэн судлаач Ц.Өнөрбаян (1995) “Монгол хэл нь угтвар, оруулбар байхгүй, язгуураас хойш нэг чигийн харьцаанд үг нь бүтэж, хувилдаг залгамал хэл билээ” гэж тэмдэглэсэн байдаг.

12. Theatre (n) /мон. театр/ → theatrical (adj) /мон. хиймэл/

Энэхүү ‘theatre’ гэдэг үг нь Британи англи хэлний үг бөгөөд ‘-ical’ дагаврыг залгахад балархай ‘e’ нь гээгдэнэ. Энэ үгийн Америк англи хэлний хувилбар нь ‘theater’ юм. Энэ тохиолдолд ‘er’ болон ‘or’ залгавраар төгссөн үгэнд эгшгээр эхэлсэн бүтээвэр залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх ‘e’ болон ‘o’ эгшиг гээгддэг дүрмийн дагуу ‘theater’ гэдэг үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх ‘e’ эгшиг гээгдэж ‘theatr’ болох бөгөөд үүн дээр ‘-ical’ дагаврыг залгаснаар ‘theatrical’ гэсэн үг маань үүсэж байна. Энэхүү ‘-ical’ дагавар нь ‘-al’ дагаврын нэг өвөрмөц хувилбар болно.

Бахаса Ингрис (2010), нэрээс тэмдэг нэр бүтээх ‘-al’ дагаврыг нэр үндсэнд залгахад “Х-д хамааралтай” утга үүснэ гэж тэмдэглэсэн байна. Доорх нэр үгст ‘-al’ дагаврыг залгахад тэмдэг нэр

дараах байдлаар үүсэж байна

- |  |   |  |
|--|---|--|
| 1. Accident (n) /мон. осол тохиолдол/    | → | accidental (adj) /мон. санамсаргүй/            |
| 2. Dent (n) /мон. шүд/                   | → | dental (adj) /мон. шүдний/                     |
| 3. Addition (n) /мон. нэмэлт/            | → | additional (adj) /мон. нэмүү, илүү/            |
| 4. Digit (n) /мон. тоо/                  | → | digital (adj) /мон. тоон систем/               |
| 5. Coast (n) /мон. эрэг/                 | → | coastal (adj) /мон. эрэг хавийн/               |
| 6. Development (n) /мон. хөгжил/         | → | developmental (adj) /мон. хөгжилтэй холбоотой/ |
| 7. Supplement (n) /мон. нэмэр, хавсралт/ | → | supplemental (adj) /мон. нэмэлт/               |
| 8. Region (n) /мон. бүс нутаг/           | → | regional (adj) /мон. бүс нутгийн/              |
| 9. Department (n) /мон. хэлтэс/          | → | departmental (adj) /мон. хэлтсийн/             |

Дээрх жишээнүүдэд, ‘-al’ дагавар нь ямар нэг авианы өөрчлөлтөд оролгүй өмнөх үгийнхээ үндсэнд шууд залгагдан тэмдэг нэр бүтээж байгааг харж болохоор байна.

Харин ‘colony’ гэдэг үгэнд энэхүү ‘-al’ дагаврыг дээрхтэй адил шууд залгаж болдоггүй зүй тогтол ажиглагдаж байна. Энэ үгэнд ‘-al’ дагаврыг залгахын тулд, авиа зүйн хоёр шат дамжих хэрэгтэй болно. Эхлээд эхний үеийн /o/ авиалбар /ə/ авиалбараар солигдоно, дараа нь ‘-al’ дагаврыг залгах үед хоёр дахь үеийн /ə/ авиалбар /ou/ хос эгшгээр солигдоно.

Авианы энэхүү зүй тогтлыг *Хүснэгт 1*-ээс дэлгэрүүлэн харж болно.

Дараах хүснэгтэд, үндсэн авиалбар (underlying representation)-ыг “YA”, авиалбарын хувилбарыг (phonological representation) “AX”, үүсэж байгаа үгийг “YU” гэж тэмдэглэсэн болно

**Хүснэгт 1**

YA	: [colony/koləni] нэр үндэс + [-al] т.н бүтээх дагавар
AX	/o/ /ə/ : [kəloni] нэр үндэс + [-al] т.н бүтээх дагавар
AX	/ə/ /ou/ : [kəloni] нэр үндэс + [-al] т.н бүтээх дагавар
YU	: [colonial / kəlonial] мон. колонийн / т.н/

2. ‘-ic’ дагаврыг нэрийн үндсэнд залгахад үүсэж буй авианы өөрчлөлт

Англи хэлний нэрээс тэмдэг нэр бүтээх бас нэг идэвхтэй бүтээвэр нь ‘-ic’ дагавар бөгөөд тухайн нэр үгийн шинж чанар оршин байгаа гэсэн утга бүхий тэмдэг нэр голдуу үүсэж байна. Англи хэлний зарим нэр үгэнд энэхүү тэмдэг нэр бүтээх ‘-ic’ дагаврыг залгахад авианы ямар өөрчлөлт гарч буйд анализ хийж үзвэл:

1. Giant (n) /мон. аварга, том/ → gigantic (adj) /мон. аварга, маш том/
2. Nomad (n) /мон. нүүдэлчин/ → nomadic (adj) /мон. нүүдэлчин, нүүдэлчний/

Дээрх хоёр жишээнд нэр үгийн үндсэнд тэмдэг нэр бүтээх дагаврыг авиа зүйн ямар нэг өөрчлөлтгүйгээр шууд залгасан байна.

3. Kaleidoscope (n) /мон. гэрлийн туйлшралын дуран/ → kaleidoscopic (adj) /мон. хурдан өөрчлөгддөг, өнгө өнгийн/

Дээрх жишээнд ‘-ic’ дагаврыг залгахад балархай ‘e’ эгшиг гээгдэж шинэ үг үүссэн байна.

4. Apocalypse (n) /мон. зөгнөн тааварлах/ → apocalyptic (adj) /мон. зөгнөлийн /

5. Chaos (n) /мон. замбараагүй байдал/ → chaotic (adj) /мон. эмх замбараагүй/

(4,5)-р жишээнд буй нэр үгс /s/ авиалбараар төгссөн бөгөөд /s/ болон /t/ авиалбаруудыг ойролцоо хамааралтай гэж үздэг. /s/ болон /t/ гийгүүлэгчид авиа бүтэх аргын хувьд ялгаатай бөгөөд /s/ гийгүүлэгч нь шүргэх (fricative) гийгүүлэгч бол /t/ гийгүүлэгч нь хамжих гийгүүлэгч (stop) билээ. Гэсэн хэдий ч ‘-ic’ дагаварт тохируулах зорилгоор /s/ гийгүүлэгч нь /t/ гийгүүлэгч болж өөрчлөгдөн шинэ үг үүсэж буй авианы өвөрмөц зүй тогтол ажиглагдаж байна.

6. Lithography (n) /мон. чулуун дээр сийлсэн/ → lithographic (adj) /мон. чулуун сийлбэрийн/

7. Melancholy (n) /мон. уйтгар, гуниг, дүйнгэ/ → melancholic (adj) /мон. уйтгартай, дүйнгэ/

Энэ нөхцөлд (6,7)-р жишээний нэр үгс нь ‘y’ авиалбараар төгссөн байгаа бөгөөд энэ нь дуудагдахдаа ‘i’-ээр дуудагддаг тул ‘-ic’ дагаврыг залгавал давхар ‘ii’ болно. Иймээс дуудахад хялбар болгох үүднээс нэг ‘i’ –г нь буюу ‘y’ авиалбарыг гээж ‘-ic’ дагавраа залган шинэ үг үүсгэж байна.

8. Metal (n) /мон. төмөр/ → metallic (adj) /мон. төмөрлөг/

Энэ жишээний хувьд ‘-ic’ дагаврыг залгахын тулд ‘l’ гийгүүлэгч давхарлан жийрэглэсэн зүй тогтол ажиглагдаж байна

9. Idiom (n) /мон. хэлц үг/ → idiomatic (adj) /мон. хэлц үгээр баялаг/

10. Phlegm (n) /мон. ноомой зан/ → phlegmatic (adj) /мон. ноомой, үлбэгэр-флегматик/

Дээрх жишээнүүдэд орсон ‘-atic’ дагаврыг зарим судлаачид ‘-ic’ болон ‘at’ залгаврын нийлц гэж үздэг байна. Харин зарим судлаачид ‘-atic’

дагаврыг ‘-ic’-ээс тусдаа бие даасан дагавар гэж үздэг бол, зарим нь ‘-ic’ -ийн нэг хувилбар гэж үздэг байна. Бид эхний баримтлалтай санал наг байгаа бөгөөд хэрвээ зөвхөн ‘-at’ гэсэн дагаврыг үгийн үндсэнд залгавал ‘idiomat’, ‘plegmat’ зэрэг тодорхой утгагүй үг үүсэх юм. Иймээс ‘-atic’ бол нэг л дагавар гэж үзэх үндэстэй байна.

Бахаса Ингрис ‘-ic’ дагаврыг нэр үгэнд залгаснаар “X-д хамаарах онцлог шинжийг илэрхийлсэн утга” бүхий тэмдэг нэр үүснэ гэсэн байна.

Зарим нэр үгийн үндсэнд –ic дагаврыг залгахад ямар нэг авианы өөрчлөлтөд оролгүй шууд залгаж болдог байхад, зарим нэр үг нь авиа зүйн нэлээд өөрчлөлтөд орж байж шинэ үг үүсдэг болохыг дараах жишээнүүдээс харж болохоор байна.

Үүнд:

- |  |   |  |
|--|---|--|
| 1. Democrat (n) /мон. ардчилсан үзэлтэн /  | → | democratic (adj) /мон. ардчилсан /           |
| 2. Artist (n) /мон. жүжигчин /             | → | artistic (adj) /мон. нарийн мэргэжлийн /     |
| 3. Hero (n) /мон. баатар /                 | → | heroic (adj) /мон. баатарлаг, эр зоригийн /  |
| 4. Diplomat (n) /мон. дипломат /           | → | diplomatic (adj) /мон. дипломатын, эелдэг /  |
| 5. Fatalist (n) /мон. фаталист/            | → | fatalistic (adj) /мон. хувь тавиланд итгэгч/ |
| 6. Atom (n) /мон. эгэл хэсэг/              | → | atomic (adj) /мон. атомын, хуваагдашгүй /    |
| 7. Hedonist (n) /мон. амьдралыг хайрлагч / | → | hedonistic (adj) /мон. амьдралд хайртай /    |

Дээрх жишээнүүдэд, ‘-ic’ дагавар нь ямар нэг авианы өөрчлөлтөд оролгүй өмнөх үгийнхээ үндсэнд шууд залгагдан тэмдэг нэр бүтээж байгааг харж болохоор байна.

Харин “academy, dogma, economy” зэрэг үгийн үндсэнд ‘-ic’ дагаврыг шууд залгалгүй авиа зүйн хэд хэдэн шат дамжсаны эцэст шинэ үг үүсэж байгааг дараах хүснэгтүүд (Хүснэгт 2, 3, 4)-ээс харж болохоор байна.

‘Academy’ гэдэг үг авиа зүйн хоёр өөрчлөлтөд орсны эцэст шинэ үг үүсэж байна. Үүнд: Хоёрдугаар үед байгаа /æ/ авиа нь авианы сулралын нөлөөгөөр /ə/ болж; ‘-ic’ дагаврыг залгах үед үгийн сүүлийн үед байсан ‘i’ гээгдэж эгшгийн сугарал болж байна. Үүнийг Хүснэгт 2-оос харж болно. Үндсэн авиалбар (underlying representation)-ыг “YA”, авиалбарын хувилбарыг (phonological representation) “AX”, үүсэж байгаа үгийг “YU” гэж хүснэгтэд тэмдэглэсэн болно.

#### Хүснэгт 2

YA		: [academy/akædəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
AX	/æ/ /ə/	: [ækədəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
AX	/ə/ /e/	: [ækədəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
AX	авиа гээгдэх /i/	: [ækədəm/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
YU		: [academic / ækədəmik/] мон. их сургуулийн /т.н/

“Dogma” гэдэг үгээс шинэ үг үүсэхдээ мөн авианы хоёр өөрчлөлтөд орж байна. Эхлээд хоёрдугаар үед байгаа /ə/ авиа /æ/ авиагаар солигдоно; дараа нь ‘-ic’ дагаврыг залгах үед хамжих /t/ авиалбарыг жийрэглэж өгнө. Үүнийг Хүснэгт 3-аас харж болно. Үндсэн авиалбар (underlying representation)-ыг “YA”, авиалбарын хувилбарыг (phonological representation) “AX”, үүсэж байгаа үгийг “YU” гэж хүснэгтэд тэмдэглэсэн болно

#### Хүснэгт 3

YA		: [dogma/dogmə/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
AX	/ə/ /æ/	: [dogmæ] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
AX	оруулбар /t/	: [dogmæt] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
YU		: [dogmatic / dogmætik/] мон. хоосон сургаалын /т.н/

Харин “Economy” гэдэг үг авиа зүйн гурван шат дамжсаны эцэст шинэ үг үүсгэсэн байна. Үүнд: Хоёрдугаар үеийн /o/ авианд авианы сулрал болж /ə/ болон өөрчлөгдсөн байна. Дараа нь гуравдугаар үед байгаа /ə/ авианд авианы чангарал болж /o/ авиагаар өөрчлөгдсөн бол, ‘-ic’ дагаврыг залгах үед үгийн үндсэнд байсан ‘i’ авиа гээгдэж шинэ үг үүссэн байна. Үүнийг Хүснэгт 4-өөс харах боломжтой. Үндсэн авиалбар (underlying representation)-ыг “YA”, авиалбарын хувилбарыг (phonological representation) “AX”, үүсэж байгаа үгийг “YU” гэж хүснэгтэд тэмдэглэсэн болно

## Хүснэгт 4

ҮА		: [economy/ikonəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
АХ	/o/ /ə/	: [ikənəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
АХ	/ə/ /o/	: [ikənəmi/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
АХ	авиа гээгдэх /i:/	: [ikənəm/] нэр үндэс + [-ic] т.н бүтээх дагавар
ҮҮ		: [economic / ikənəmik/] мон. эдийн засгийн /тэ.н/

## Дүгнэлт

- Нэрээс тэмдэг нэр бүтээх *-al* болон *-ic* дагаврыг залгахад тухайн нэр үгийнхээ төгсгөл болон бүтэц, бүрэлдэхүүнээс хамааран авиа зүйн дараах өөрчлөлтүүд явагдаж байгааг анзаарч болохоор байна. Үүнд:
  - эгшгийн сэлгэц (vowel alternation) явагдаж байна. Жишээ нь: Abdomen /n/ /мон. гэдэс хэвлий/ abdominal /adj/ /мон. гэдэстэй/),
  - зарим үгэнд дагавар залгахад нэг бус нэлээд хэдэн авиа зүйн өөрчлөлтөд орж байж шинэ үг үүсэж байгаа сонирхолтой байдал ажиглагдаж байна.
- /s/ болон /t/ гийгүүлэгчид авиа бүтэх аргын хувьд ялгаатай бөгөөд /s/ гийгүүлэгч нь шүргэх (fricative) гийгүүлэгч бол /t/ гийгүүлэгч нь хамжих гийгүүлэгч (stop) боловч *'-ic'* дагаварт тохируулах зорилгоор /s/ гийгүүлэгч нь /t/ гийгүүлэгч болж өөрчлөгддөгийг түүвэрлэсэн баримтаас харж болохоор байна.
- Тухайн үг нь Британи англи (British English) үг үү, эсвэл Америк англи (American English) үг үү гэдгээсээ хамааран үг бүтэх явцад гарах авианы хувьсал нь өөр өөр байх явдал ажиглагдлаа. Тухайлбал, *'theatre'* гэдэг үг нь Британи англи хэлний үг бөгөөд *'-ical'* дагаврыг залгахад балархай *'e'* гээгдэнэ. Энэ үгийн Америк англи хэлний хувилбар нь *'theater'* юм. Энэ тохиолдолд *'er'* болон *'or'* залгавраар төгссөн үгэнд эгшгээр эхэлсэн бүтээвэр залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх *'e'* болон *'o'* эгшиг гээгддэг дүрмийн дагуу *'theater'* гэдэг үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх *'e'* эгшиг гээгдэж *'theatr'* болох бөгөөд үүн дээр *'-ical'* дагаврыг залгаснаар *'theatrical'* гэсэн үг маань үүсэж байна. Энэхүү *'-ical'* дагавар нь *'-al'* дагаврын нэг өвөрмөц хувилбар болно

## Ашигласан материал

- Өнөрбаян, Ц. (1995). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар
- Бямбасан, П. (1975). *Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг*. Улаанбаатар
- Оюунцэцэг, Ж. (2000). *Англи хэлний зүй*. Улаанбаатар
- Adams, Valerie. (1973). *An Introduction to Modern English Word-formation*. London: Longman
- Bahasa, Inggris. (2010). *The Formation of English Adjective through Derivation*. Indonesia
- Bauer, Laurie. (1983). *English Word-formation*. Cambridge: Cambridge University Press
- Hladky, Josef. (1998). *A Functional Onomatology of English*. Brno: Masarykova Universita
- Jenny Dooley-Virginia Evans. (2008). *Grammarway*. Express Publishing
- Maretha eka Aulia. (2009). *A Morphological process in English adjective formation*.
- Raymond Murphy. (1998). *English grammar in use*. Cambridge